



**УВС АЙМАГ ДАХЬ ЗАХИРГААНЫ
ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН
ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨНИЙ ТОГТООЛ**

2025 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 124/ЗТ2026/0001

Улаангом сум

**Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, даалгавар,
хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг маргааныг
хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар
томилох журам батлах тухай**

Тус шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнийг Ерөнхий шүүгч Д.Алтанцэцэг даргалан шүүгч О.Батдорж, шүүгчийн туслах Б.Байгальмаа нарыг байлцуулан Шүүхийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д зааснаар нийт шүүгчдийн чуулганы 2021 оны 9 дүгээр сарын дугаар сарын 11-ний өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан Хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нийтлэг журам, Нийт шүүгчдийн чуулганы 2023 оны 09 сарын 28-ны өдрийн 04 Тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах тухай 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн шүүхэд хэрэг, нэхэмжлэл, хүсэлт, гомдол хүлээн авах, шүүгчид хуваарилах, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг томилох журам батлах тухай хэлэлцээд,

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2.2, 19.2.5, 19.3 дахь хэсэг, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.2, 72 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1 дахь хэсэгт заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Шүүхэд хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, даалгавар, хүсэлт хуваарилах, хэрэг маргаан хянан шийдвэрлэх шүүгч болон шүүх хуралдаан даргалагчийг томилоход сугалааны дагуу 1.Ерөнхий шүүгч Д.Алтанцэцэг, 2.шүүгч О.Батдорж гэсэн дарааллаар Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системд бүртгэсүгэй,

2.Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, даалгавар, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журмыг хавсралтаар баталсугай.

ДАРГАЛАГЧ, ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

ШҮҮГЧ

Д.АЛТАНЦЭЦЭГ

О.БАТДОРЖ



850260004

Увс аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт, даалгавар хүлээн авах, хуваарилах болон шүүх хуралдаан даргалагч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох журам

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт, даалгавар хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилоход хуульд заасан шаардлага хангасан программ хангамж ашиглана. Программ хангамжийн ажиллагаа болон аюулгүй байдлыг Шүүхийн тамгын газар хариуцна.

1.2. Нэгдсэн системд байрших тойрогт шүүгчдийн нэрсийн дарааллыг тухайн тайлант оны эхэнд шүүгчдийн зөвлөгөөнөөр сугалаагаар тогтоож Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системд-д байршуулах үүргийг мэдээлэл технологийн мэргэжилтэн хариуцна.

1.3. Шүүхийн тамгын газрын мэдээлэл лавлагааны мэргэжилтэн шүүхэд ирсэн хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт, даалгаврыг хүлээн авсан даруйд нэгдсэн системд оруулан хуваарилалт хийж, дардас даран хүлээн авсан бүртгэлийн дэвтэрт цаг, минутын дарааллаар бүртгэн хуваарилагдсан шүүгчид хүлээлгэж өгнө. Шүүгчид хүлээлгэн өгөх боломжгүй байгаа бол шүүгчийн туслахад гарын үсэг зуруулж хүлээлгэн өгнө.

Хоёр. Хэрэг хуваарилах арга сонгох

2.1 Шүүхэд ирсэн хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт, даалгавар, адил шатны шүүхээс шилжиж ирсэн хэрэг, харьяалал тогтоож ирүүлсэн хэргийг нэгдсэн системээс урьдчилан мэдэх боломжгүй, тойрог дотор санамсаргүй тохиолдлын аргаар хуваарилах аргыг ашиглана.

2.2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэг, 109 дүгээр зүйлийн 109.2 дахь хэсэгт зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг давж заалдах шатны шүүхээс хүчингүй болгосон, мөн хуулийн 53 дугаар зүйлийн 53.3 дахь хэсэг, 91 дүгээр зүйлийн 91.3 дахь хэсэгт зааснаар нэхэмжлэлийг буцаасан асуудлаар нэхэмжлэгч шүүхэд дахин нэхэмжлэл гаргасан тохиолдолд нэхэмжлэл, хэргийг өмнө нь хүлээн авсан шүүгчид нэгдсэн системээс гараар хуваарилах аргыг сонгож хуваарилна.

2.3. Дараах тохиолдолд тухайн шүүгчийг тойргоос гарган бусад шүүгч нарт тойрог дотор санамсаргүй байдлаар хуваарилна.

2.3.1 Давж заалдах болон хяналтын шатны шүүхээс шийдвэрийг хүчингүй болгож дахин хэлэлцүүлэхээр буцаасан;

2.3.2 Тухайн шүүхийн бүх шүүгчийн шийдсэн шийдвэр хүчингүй болсон тохиолдолд нийт шүүгч нараасаа тойрог дотор санамсаргүй байдлаар хуваарилан хуваарилагдсан шүүгч Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1.6 дахь хэсэгт заасны дагуу татгалзан гарна.

2.3.3 Шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас шийдвэрийг хүчингүй болгож дахин хэлэлцүүлэхээр буцаасан;

2.3.4 Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр хэрэг маргааныг хянан шийдвэрлэхээс шүүгч өөрөө татгалзан гарсан, шүүгчийг татгалзан гаргасан;

2.3.5. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1 дэх хэсэгт зааснаар шийдвэрийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянуулах тухай хүсэлт гаргасан;

2.3.6 Тухайн шүүхэд шүүгч шинээр томилогдсон, сэлгэн ажиллах болсон, мөн шүүгч чөлөөтэй, өвчтэй, томилолттой байх хугацаанд тухайн шүүхэд шинээр ирсэн нэхэмжлэл, хэргийг ачаалал тэнцвэржүүлэх шаардлагатай болсон тохиолдолд хэдэн хэргийг хуваарилах асуудлыг тухай бүр нь зөвлөгөөнөөр хэлэлцэж, сугалаагаар сонгож шилжүүлнэ.

2.4 Хэрэг тусгаарлаж байгаа тохиолдолд тухайн хэргийг тусгаарласан шүүгчид хэргийг гараар хуваарилах,

2.5 Хэрэг нэгтгэж байгаа тохиолдолд хамгийн сүүлд захиргааны хэрэг үүсгэсэн шүүгч дээр хэргийг нэгтгэн гараар хуваарилах

Гурав. Хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүгч,
шүүх бүрэлдэхүүнийг томилох

3.1 Шүүх хуралдаан даргалагч болон шүүх бүрэлдэхүүнийг томилсон шүүгчдийн зөвлөгөөний тогтоол, журмаар тогтоосон дарааллын дагуу Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системээс хуваарилсныг Ерөнхий шүүгч Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3-т зааснаар захирамж гаргаж албажуулна.

3.2 Хэрэг маргааныг хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн тус шүүхэд хүрэлцэхгүй байгаа тохиолдолд шүүх бүрэлдэхүүнд адил шатны өөр шүүхийн шүүгчийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.6 дахь хэсэгт зааснаар адил шатны өөр шүүхийн Ерөнхий шүүгчтэй зөвшилцөж, тухайн шүүхийн Ерөнхий шүүгчийн захирамжаар өөр шүүхийн шүүгчийг бүрэлдэхүүнд томилж, оролцуулна.

3.3 Шүүх бүрэлдэхүүнтэй хэлэлцэх хэргийн шүүх хуралдаанд илтгэгч шүүгчийг даргалагчаар томилж, Ерөнхий шүүгч захирамж гаргаж албажуулна.

3.4 Өөр шүүхээс шүүх бүрэлдэхүүнд нэг шүүгч томилуулан ажиллуулах хүсэлт ирсэн тохиолдолд томилогдох шүүгчийг сугалаагаар тогтооно. Хоёр шүүгч томилуулан ажиллуулах хүсэлт ирсэн тохиолдолд тус шүүхийн хоёр шүүгчийг зөвлөгөөний тогтоолоор томилно.

3.5 Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.5-д заасны дагуу тухайн жилийн турш шүүгчийн ажлын ачаалал ихэссэн, ажиллах шүүгчдийн тоо нэмэгдсэн, хасагдсаны улмаас энэ хуулийн 72.1, 72.2-т заасны дагуу хянан шийдвэрлэх боломжгүй тохиолдолд Ерөнхий шүүгч тухай бүр шүүгчдийн зөвлөгөөнийг зарлан хуралдуулж, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийг тухай бүр журамд нэмэлт өөрчлөлт оруулж шийдвэрлэж байхаар тогтоосугай.

Дөрөв. Бусад

4.1 Гүйцэтгэх хуудас олгохыг хүссэн хүсэлтийг тухайн хэргийг шийдвэрлэсэн шүүгчид хуваарилна. Тухайн шүүгч чөлөөтэй, ээлжийн амралттай, албан тушаалаас чөлөөлөгдсөн тохиолдолд сугалаагаар бусад шүүгчдэд хүсэлтийг хуваарилна.

4.2 Ажлын 5 өдрөөс дээш өвчтэй, чөлөөтэй байгаа бол хэрэг, нэхэмжлэл, өргөдөл хуваарилахгүй, ажлын 10 өдрөөс дээш хугацаагаар өвчтэй, чөлөөтэй бол хэргийг шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцэж шүүгчид хуваарилна.

4.3 Шүүгч ээлжийн амралт авсан бол тухай бүрд нь нэхэмжлэл, хэргийг шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцэн, шүүгч ээлжийн амралттай байх хугацаандаа хэрэг хянан шийдвэрлэх эсэх, шүүх бүрэлдэхүүнд оролцох эсэх, хэргийг өөр шүүгчид шилжүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

4.4 Шүүгч чөлөөний болон ээлжийн амралтын хугацаа дуусаж ажилд буцан ороход шилжүүлсэн хэргээс шийдвэрлэгдээгүй үлдсэн хэргийг буцаан шилжүүлнэ

4.5 Шүүгчийн чөлөөний хугацаа дуусахаас дөрөв хонгийн өмнө нэхэмжлэл, хэргийг уг журмын 2.1-д зааснаар хуваарилна.

Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх